# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 02 дугаар сарын 12 Улаанбаатар хот

## Нэг. Танилцуулга

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад тогтоол шийдвэрийн хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжиж буй дүрэм журмын хэрэгжилтийн байдалд 2026 оны 02 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/223 дугаар тушаалаар батлагдсан Үнэлгээний багийн гишүүд хяналт, шинжилгээ хийж ажиллалаа.

Үнэлгээний багийн бүрэлдэхүүнд Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн О.Янжинлхам, мэргэжилтэн Б.Мөнхзул, Ш.Оюун-Эрдэнэ, Л.Оюундарь нар ажиллалаа.

## Хоёр. Хяналт-шинжилгээний зорилго, хамрах хүрээ

Энэхүү хяналт-шинжилгээний зорилго нь дүүргийн Засаг даргын захирамж болон Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар батлагдсан Засаг даргын тамгын газарт хэрэгжиж буй 38 дүрэм, журмын эрх зүйн үндэслэл, давхардал, хийдэл болон бодит хэрэгжилтэд үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулахад оршино.

## Гурав. Хяналт-шинжилгээний нэгдсэн дүн

Хяналт–шинжилгээнд дүүргийн Засаг даргын захирамж 20, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 18 нийт 38 эрх зүйн актыг хамруулж ажиллалаа.

| Д/д | Баримт бичгийн нэр | Хүчингүй | Засвар өөрчлөлт оруулах шаардлагатай | Үйлчлэл хэвийн |
|---|---|---|---|---|
| 1 | Захирамж | 5 | 5 | 10 |
| 2 | Тушаал | 4 | 3 | 11 |

## Дөрөв. Дүгнэлт

### Дүүргийн Засаг даргын захирамж

Дүүргийн Засаг даргын 2006 оны А/339 “Санал асуулга авах журам батлах тухай”А/339, “Журам батлах тухай” А/344 (дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс албад, тасаг хороодын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам), “Ёс зүйн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай” А/485 дугаар захирамжуудыг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/104 дүгээр захирамжаар, 2022 оны дүүргийн “Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай”А/235 дугаар захирамжийг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/145 дугаар захирамжаар, “Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дүрэм шинэчлэн батлах тухай” А/116 дугаар захирамжийг

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/764 дүгээр захирамжаар тус тус хүчингүй болгосон.

Дүүргийн Засаг даргын 2023 оны А/267 дугаар захирамжаар батлагдсан "Хүүхдийн сургуулийн автобусыг ажиллуулах журам" –аар зохицуулагдаж байсан чиг үүрэг нь нийслэлийн Боловсролын газар, Автобус баазууд руу шилжсэн тул хүчингүй болгох саналтай байна.

Дүүргийн Засаг даргын 2023 оны "Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/183 дугаар захирамжаар батлагдсан Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны дүрэм нь жендерийн салбар хорооны дүрэм, журамтай холилдон батлагдсан, 2024 оны "Журам батлах тухай" А/613 захирамжаар батлагдсан "Хот нийтийн аж ахуйн гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжүүлэх, тайлагнах журам" нь найруулга зүй, үг үсгийн алдаа их учраас тус тус засварлах шаардлагатай байна.

Дүүргийн Засаг даргын 2014 оны "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн салбар хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" А/196 дугаар захирамжийн үндэслэл хэсэгт заасан хуулийн зүйл заалтын үйлчлэл хүчин төгөлдөр бус болсон, 2023 оны дүүргийн "Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай" А/145 дугаар захирамжийн үндэслэл хэсэгт авсан Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаал нь хүчин төгөлдөр бус болсон тул шинэчлэн гарсан хууль, тогтоомжид нийцүүлэн шинэчлэн гаргах нь зүйтэй гэж үзлээ.

Засаг даргын Тамгын газрын даргын тушаал

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2010 оны "Журам батлах тухай" (Засаг даргын Тамгын газрын ажилтнууд, хороод хариуцан ажиллах журам) А/39 дүгээр тушаалыг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/23 дугаар тушаалаар, 2019 оны "Журам батлах тухай" (Тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хадгалах ашиглах журам) Б/189 дүгээр тушаалыг 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/83 дугаар тушаалаар, 2023 оны "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалтын журам) А/36 дугаар тушаалыг 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар, 2023 оны "Журам батлах тухай" (Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга нарын шуурхай хуралдааны журам) А/50 дугаар тушаалыг 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/40 дүгээр тушаалаар тус тус хүчингүй болгосон.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2017 оны "Дүрэм батлах тухай" (Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын архивын дүрэм) А/38, "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын албан хэрэг хөтлөлтийн журам) А/113, 2022 оны "Журам батлах тухай" (Тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хадгалах, ашиглах журам) А/102 дугаар тушаалаар батлагдсан дүрэм, журам нь Монгол Улсын "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (2020 оны шинэчилсэн найруулга)-ийн ерөнхий шаардлага, "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам" зэргийг үндэслэн шинэчлэх шаардлагатай байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны "Журам батлах тухай" (Серверийн өрөө, хайрцгийг ашиглах журам) А/44 дүгээр тушаалд үндэслэл

болгон авсан Засгийн газрын 2011 оны 312 дугаар тогтоол хүчингүй болсон, 2023 оны "Журам батлах тухай" А/105 дугаар тушаалаар батлагдсан "Сонгинохайрхан дүүрэг" цахим хуудас ажиллуулах, мэдээ мэдээлэл байршуулах журамд "Кибер аюулгүй байдлын тухай хууль"-д нийцүүлэн журмын 7 дугаар бүлэгт системийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас сэргийлэх техникийн зохицуулалтыг илүү нарийвчлан тусгаж тус тус шинэчлэх шаардлагатай байна.

Дүүргийн Засаг даргын 2021 оны "Журам батлах тухай" (Дүүргийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам) А/591, 2023 оны "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам) А/06, А/364 "ERP систем ашиглах журам батлах тухай" А/364, "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Гэрлэх ёслолын өргөөний үйлчилгээний журам) А/433, 2024 оны "Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай" А/320, 2025 оны "Журам батлах тухай" (Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан, хороодын Засаг дарга нарын нэгдсэн шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам) А/18, "Журам батлах тухай" (Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах дулаан автобусны буудлуудын ашиглалтын журам) А/36, "Ажлын хэсэг байгуулах тухай" (Сонгинохайрхан дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтын журам) А/162, "Дүүргийн Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүн, хуралдааны журмыг шинэчлэн батлах тухай" А/209, Сонгинохайрхан дүүргийн оны тэргүүний байгууллага, төрийн албан хаагч, ажилтнуудыг шалгаруулахад нэр дэвшүүлэх төрөл, шалгуур үзүүлэлтийг батлах тухай" А/716 дугаар **захирамжууд,** Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны "Журам батлах тухай" (Серверийн өрөө, хайрцгийг ашиглах журам) А/44, "Засаг даргын Тамгын газрын байранд мөрдөх журам батлах тухай" А/47, 2022 оны "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газарт гэрээ байгуулах журам) А/136, "Журам батлах тухай" (Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байр, албан хаагчдын өрөө тасалгаанд хийх их цэвэрлэгээнд мөрдөн журам) А/151, 2024 оны "Журам шинэчлэн батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын цаг ашиглалтын журам) А/29, "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн хороодын Засаг дарга нарын шуурхай хуралдаан зохион байгуулах журам) А/40, "Журам батлах тухай" (Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн дарга нарын шуурхай хуралдааны журам) А/41, "Журам батлах тухай" (Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын цалин хөлсний журам) А/52, 2025 оны Дүүргийн Засаг даргын Тамгын газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн батлах тухай А/77 дугаар **тушаалууд** хэвийн үйлчилж байна.

Олон жилийн өмнө батлагдсан (2006, 2013 оны) журмууд нь шинээр батлагдсан хууль тогтоомж, үнэлгээний нийтлэг журмуудтай зөрчилдөж, эрх зүйн чадамжгүй болсон байгаа тул шинэчлэгдсэн хууль, эрх зүйн актуудад нийцүүлж шинэчилэх, хүчингүй болгох

Захирамжлалын баримт бичгээр батлан гаргасан гэрээ, журам-д Үндсэн хууль, Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад холбогдох хуулийг мөрдлөг болгоно гэж заасан боловч захирамж, тушаалын үндэслэл хэсэгт тусгаагүй орхигдуулсан.

Дүүргийн хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журмуудыг шинэчилсэн хууль тогтоомжид нийцүүлэх, санхүүгийн эх үүсвэр болон хариуцлагын механизмыг нарийвчлан тусгаж, үйл ажиллагааны процессыг тодорхой болгох замаар эдгээр хийдлүүдийг арилгах шаардлагатай байна.

Захирамж, тушаалаар гарсан баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж ажиллах дараах 3 үндсэн төрлийн давхардал байна: Үүнд:

1. Эрх зүйн актуудын давхардал (Хуулийн заалтыг шууд хуулбарлах)
   Захирамж, тушаалаар баталсан журамд хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн заалтуудыг өөрчлөлтгүйгээр шууд хуулбарлан оруулсан нь журмын бие даасан байдлыг алдагдуулж, хуульд өөрчлөлт орох бүрт журмыг шинэчлэх шаардлага үүсгэж байна. Жишээ: Иргэдтэй хийх уулзалтын журам (А/162)-д "Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль"-ийн заалтуудыг , Хүүхдийн сургуулийн автобусны журам (А/267)-д Замын хөдөлгөөний дүрмийн хүүхэд тээвэрлэх тусгай зохицуулалтуудыг тус тус давхардуулан заажээ.

2. Чиг үүрэг болон ажлын байрны тодорхойлолттой давхцах байдал

- Илэрсэн байдал: Захирамж, тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг эсвэл комиссын чиг үүрэг нь тухайн албан тушаалтны үндсэн ажлын байрны тодорхойлолттой давхцаж байна.
- Жишээ: Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын (А/320) гишүүдийн үүрэг нь тэдний Архивын тасгийн мэргэжилтний чиг үүрэгтэй , Ажлын хэсэг (А/162)-т өгсөн өргөдөл гомдол шийдвэрлэх үүрэг нь холбогдох мэргэжилтнүүдийн үндсэн үүрэгтэй тус тус давхардсан.

3. Хуучин болон шинэ баримт бичгийн давхардал

- Илэрсэн байдал: Шинэ журам батлахдаа өмнө нь гарсан ижил төрлийн баримт бичиг нь хүчин төгөлдөр бус болсон боловч албан ёсоор хүчингүй болгоогүй байх тул захирамж, тушаалтай давхцах тохиолдол байна.
- Жишээ: Гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагааны журам нь 2022 оны А/235 болон 2023 оны А/145 дугаар захирамжуудаар давхардан зохицуулагдсан байна. Мөн ажилчдын ажлын цаг ашиглалтын журамд 2023 оны А/36 болон 2024 оны А/29 дүгээр тушаалууд давхардсан бөгөөд өмнөх тушаалыг хүчингүй болгох заалт ороогүй байна.

Нэгдсэн дүгнэлт: Дээрх давхардлууд нь эрх зүйн баримт бичгийн хэрэглээнд тодорхойгүй байдал үүсгэж, хяналт-шинжилгээний ажлыг хүндрүүлж байна. Иймд шинээр дүрэм, журам батлахдаа өмнөх захирамж, тушаалыг хүчингүй болгох заалтыг заавал оруулах, хуулийн заалтыг шууд хуулбарлахгүйгээр иш татах, албан хаагчдын үндсэн чиг үүрэгтэй уялдуулан зааг ялгааг гаргах шаардлагатай байна.

## Тав. Санал

1.Захирамж, тушаалын үндэслэл хэсэгт заасан хуулийн зүйл заалт нь хүчин төгөлдөр байгаа эсэхийг холбогдох хэлтэс, тасаг тухай бүр шалгаж хэвших, хуулийн шинэчлэлд нийцүүлэх,

2.Эрх зүйн хэм хэмжээний эрэмбийг баримталж, дүүргийн түвшний баримт бичигт нийслэлийн албан тушаалтны эрхийг заасан алдааг засварлах

3.Баримт бичгийг баталсан өдрөөс өмнөх хугацаанд ухраан мөрдөх заалт оруулахгүй байх

4.Албан хэрэг хөтлөлтийн MNS 5140:2021 стандартыг мөрдөж ажиллах (журмын зүйл заалтын дугаарлалт давхардах, алгасах зөрчлийг арилгах, хяналтыг сайжруулах)

5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ТАЙЛАН БИЧСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.ЯНЖИНЛХАМ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2014 оны 06 дүгээр сарын 09, А/196<br>"Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн салбар хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -МУЗЗНДНТУТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр баталсан хуулиар хүчингүй болсон,<br>-МУ-ын Их хурлын 2003 оны 41 дүгээр тогтоол- Хүчинтэй,<br>-МУ-ын ЗГ-ын 2005 оны 167 дугаар тогтоол-Хүчинтэй<br>***Журамд тусгагдсан эрх зүйн актууд:***<br>-Монгол Улсын Үндсэн хууль |
| | | Давхардал | Байхгүй |
| | | Хийдэл | Дүрмийн 1.2-т Монгол Улсын Үндсэн хуулийг мөрдлөг болгоно гэж заасан байгаа боловч энэ нь Захирамжийн үндэслэл хэсэгт тусгагдаагүй байна. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Монгол Улсын хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг өөрийн байгууллагын хэмжээнд болон харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд зохион байгуулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх; |
| Дүгнэлт:<br>Тус захирамжийн үндэслэл болсон гол хууль болох Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 2020 онд хүчингүй болсон байна. Мөн Засаг даргын Тамгын газрын бүтэц жил бүр шинэчлэгдэн батлагддаг. Хамгийн сүүлд 2025 онд шинэчлэгдэн батлагдсан. Гэтэл Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн салбар хорооны бүрэлдэхүүн нь хуучин бүтцийн дагуу байгаа бөгөөд зарим хэлтсүүд одоо байхгүй зарим нь нэршил өөрчлөгдсөн. Хүчин төгөлдөр хууль эрх зүйн хүрээнд томоохон хийдэл байхгүй хэдий ч захирамжийн үндэслэл хэсэгт тусгагдаагүй хууль эрх зүйн зохицуулалтыг дүрэмд мөрдлөгө болгоно гэж заасан өгсөн байна. Тиймээс уг журмыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, засаг даргын тамгын газрын бүтцэд нийцүүлэн зайлшгүй шинэчлэн гаргах шаардлагатай байна. | | | |

ТАНИЛЦСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА [signature] С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН [signature] Л.ОЮУНДАРЬ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 10 өдөр

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2021 оны 09 дүгээр сарын 27, А/591<br>Журам батлах тухай<br>Дүүргийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “г” дахь хэсэг, 29.2 *(Хүчинтэй.)*<br>-Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг *(Хүчинтэй)*<br>-Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал *(Хүчинтэй)* |
| | | Давхардал | Давхардал байхгүй |
| | | Хийдэл | **Шийдвэрлэх хугацаа:** 6.4-т иргэний өргөдлийг 30 хоногийн дотор шийдвэрлэхээр заасан боловч, 6.5-д заасан "хойшлуулшгүй нөхцөл байдал" үүссэн үед хэд хоногийн дотор шийдвэрлэх тусгайлсан богино хугацааг зааж өгөөгүй байна.<br>**Давхардуулан олгохгүй байх хугацаа:** 6.9-д "давхардуулан олгохгүй" гэж заасан боловч энэ нь нэг удаагийн тусламж авсан иргэн дараа жил нь дахин хүсэлт гаргаж болох эсэх, эсвэл амьдралдаа зөвхөн нэг удаа авах уу гэдэг хугацааны хязгаарыг тодорхой заагаагүй байна. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | **Эрүүл мэндийн шалтгаан:** Өндөр үнэтэй эмчилгээ тогтмол хийлгэж буй иргэн, хүүхэд<br>**Нийгмийн халамж:** Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний асран хамгаалагч; тэжээн тэтгэх хүнгүй, орон гэргүй ахмад настан; ажилгүй бөгөөд 2-оос дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх.<br>**Гэнэтийн нөхцөл байдал:** Гэнэтийн аюул, осол, гамшигт нэрвэгдсэн иргэд.<br>**Харьяалал:** Иргэн нь Сонгинохайрхан дүүргийн харьяалалтай байх шаардлагатай (гамшигт нэрвэгдсэн иргэн түр оршин суугч байж болно). |
| Дүгнэлт: Энэхүү журам нь дүүргийн түвшинд нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд хүргэх, нөөц хөрөнгийг зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн ач холбогдолтой баримт бичиг болсон байна. Гэвч баримт бичгийн огноо, дугаарлалт зэрэг техникийн алдаанууд нь албан хэрэг хөтлөлтийн шаардлагыг бүрэн хангаагүй байгаа тул эдгээр зөрүүг арилгаж, нэг мөр болгох шаардлагатай гэж үзэж байна. | | | |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.МӨНХЗУЛ

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2022 оны 04 дүгээр сарын 28, А/235 “Дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” | Хэрэгжиж буй эсэх | Дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/145 дугаар захирамжаар **хүчингүй болгосон.** |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1-хүчинтэй<br>-Гамшгаас хамгаалах тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолыг үндэслэсэн-хүчинтэй |
| | | Давхардал | Дүүргийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/145 дугаар захирамжтай давхардаж байна. |
| | | Хийдэл | байхгүй |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах, эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах, гамшиг ослын үед нэрвэгдсэн иргэдэд тусламж үзүүлэх, дэд бүтцийг сэргээн босгох. |

**Дүгнэлт:** Захирамжаар дүүргийн хэмжээнд гамшгаас хамгаалах тогтолцоог бэхжүүлэх, болзошгүй аюулын үед ажиллах алба, мэргэжлийн ангиудын бүтэц, чиг үүргийг тодорхой болгоход чиглэгдсэн эрх зүйн баримт бичиг.
Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх байгууллага бүрийн хариуцах ажил, нөөц бүрдүүлэлт, техникийн бэлэн байдлыг нарийвчлан зааж өгснөөр хариуцлагын тогтолцоог тодорхой тусгасан.

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.ОЮУН-ЭРДЭНЭ

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 10

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2023 оны 01 дүгээр сарын 05,<br>А/06<br>Сонгинохайрхан дүүргийн засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг - Хүчинтэй.<br>Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалт - Хүчинтэй.<br>Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол - Хүчинтэй |
| | | Давхардал | Байхгүй |
| | | Хийдэл | Журмын 4.4.3-т зөрчил гаргагчид хариуцлага ногдуулах санал гаргах тухай заасан бөгөөд ямар төрлийн хариуцлага ногдуулах нь тодорхой бус байна. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Энэхүү журмын зорилго нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.<br>Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний харилцааг зохицуулсан. |
| Дүгнэлт:<br>2026 оны А/38 дугаар захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ журам нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг тогтмол, үр дүнтэй зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй арилгах үйл ажиллагааг тодорхойлсноор байгууллагын ажлын хяналт, зохион байгуулалтын түвшинг дээшлүүлэх, ажлын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АЖИЛТАН Ш.ОЮУН-ЭРДЭНЭ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2023 оны 03 дугаар сарын 15, А/145<br>“Дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг шинэчлэн байгуулах, ажиллах журам батлах тухай” | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -МУЗЗНДНТУТХ-ийн 66 дугаар зүйлийн 66.1-Хүчинтэй,<br>-Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, 24 дүгээр зүйлийн 24.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.10 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг- Хүчинтэй<br>-Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаал-Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/83 дугаар тушаалаар хүчингүй болсон.<br>***Журамд тусгагдсан эрх зүйн актууд:***<br>-Мэргэжлийн ангийн дүрэм<br>-Улсын шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаал |
| | | Давхардал | Байхгүй |
| | | Хийдэл | Захирамжийн үндэслэл хэсэгт тусгаж өгөөгүй боловч гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажиллах журмын 3.1.3 дахь заалтад Монгол Улсын шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тушаал, Мэргэжлийн ангийн дүрмийг дагаж мөрдөнө гэж заасан байна. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгах |

Дүгнэлт:
Журмын агуулга нь гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн нийтлэг үндэслэл, зорилго, Засаг даргын эрх үүрэг, Онцгой байдлын хэлтсийн чиг үүрэг, албаны чиг үүрэг, штабын дарга болон ажилтнуудын эрх үүрэг, сургалт, санхүүжилт зэргийг нарийвчлан заасан байгаа нь "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн 33 дугаар зүйлд заасан орон нутгийн албаны чиг үүрэгтэй бүрэн нийцэж байгаа ч Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/83 дугаар тушаалаар хүчингүй болгосон байна. Иймээс Мэргэжлийн ангийн дүрмийг шинэчлэн боловсруулан батлах шаардлагатай гэж үзэж байна.

ТАНИЛЦСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Л.ОЮУНДАРЬ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 дугаар сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2023 оны 03 дугаар сарын 24,<br>А/183<br>Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хорооны дүрэм, бүрэлдэхүүнийг шинэчилэн батлах тухай | Хэрэгжиж буй эсэх | Үгүй |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | Хүүхэд хамгааллын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт (Хүчингүй) 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан хуулиар хүчингүй болсон.<br>Засгийн Газрын гишүүн мэргэжлийн холбоотой үндэслэл буруу. |
| | | Давхардал | Давхардаагүй |
| | | Хийдэл | Баримт бичгийн эхний хэсэг болон хавсралт нь **"Нийгмийн ажилтны ёс зүйн салбар хороо"**-ны тухай боловч, 4-р хуудаснаас эхлэн агуулга нь бүхэлдээ **"Жендэрийн салбар хороо"** ны чиг үүрэг болон хувирсан байна. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээний үнэт зүйлс, зарчмыг тодорхойлох, төрийн болон төрийн бус байгууллагын нийгмийн ажлын үйлчилгээ, мэргэжлийн удирдлага, шийдвэр гаргах явцад мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтооно. Нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн үүргийг тодорхойлох чиг үүрэгтэй. |
| Дүгнэлт:<br>Захирамжаар батлагдсан журам утга агуулгын хувьд ижил төстэй журамтай холилдсон байх нөхцөл байдал байна. Иймд энэ журмыг холбогдох хэлтсээр (боловсруулсан мэргэжилтнээр) дахин нягтлуулж, засвар өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзлээ. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.ЯНЖИНЛХАМ

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 11 өдөр

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2023 оны 04 дүгээр сарын 26, А/267<br><br>“Журам батлах тухай”<br><br>“Хүүхдийн сургуулийн автобусыг ажиллуулах журам” | Хэрэгжиж буй эсэх | Засаг даргын Тамгын газраас тухайн төслийг хэрэгжүүлэхээ больсон. |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1- хэрэгжиж байгаа<br>-Авто тээврийн тухай хуулийн 7.1.1, 7.1.4- хүчин төгөлдөр үйлчилж байгаа<br>-Боловсролын тухай хуулийн 31.1.1- хүчин төгөлдөр үйлчилж байгаа<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйл- хүчин төгөлдөр үйлчилж байгаа<br>-Төсвийн тухай хуулийн 14.2.3, 41.2.2- хүчин төгөлдөр үйлчилж байгаа<br>-Замын хөдөлгөөний дүрэм (2018 оны 239 дүгээр тогтоол)- хүчин төгөлдөр үйлчилж байгаа<br>-Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/110 дугаар захирамж- хүчин төгөлдөр үйлчилж байгаа |
| | | Давхардал | -Замын хөдөлгөөний дүрэмтэй давхардсан заалт: Журмын 7.2 дахь заалтад "Өдрийн цагт ойрын гэрлээ асааж замын хөдөлгөөнд оролцох", "Хурдны дээд хязгаарыг 50 км/цагаас хэтрүүлэхгүй байх" гэсэн нь Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм"-ийн хүүхэд тээвэрлэх тусгай зохицуулалтуудтай давхцаж байна. |
| | | Хийдэл | -Автобус техникийн саатлын улмаас явах боломжгүй болсон тохиолдолд сурагчдыг хэрхэн тээвэрлэх талаар журамд тусгаагүй байна.<br>-Тээвэрлэлтийн явцад хүүхдийн эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд даатгалын компани болон тээвэрлэгч байгууллагын хоорондын харилцааг нарийвчлан заагаагүй |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | -Сургуулийн автобус хүлээн авах, хуваарилах, тээвэрлэлтийн гэрээ байгуулах.<br>-Сургуулийн автобусны чиглэл маршрут, цагийн хуваарийг батлах.<br>-Жолооч болон хүүхэд зохицуулагчийг томилж, гэрээ байгуулан ажиллах. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | -Хүүхдийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, хяналт тавих |
| **Дүгнэлт:** Журмаар сурагчдыг аюулгүй, стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох талуудын эрх үүргийг зааглан өгсөн.<br>Засаг даргын Тамгын газраас төслийг хэрэгжүүлэхээ больсон тул хүчингүй болгох. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.ОУЮН-ЭРДЭНЭ

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 дугаар сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2023 оны 05 дугаар сарын 31<br>А/364<br>ERP систем ашиглах журам батлах тухай | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | МУЗЗНДНТУТХ-ийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх хэсэг - Хүчинтэй<br>Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Журам батлах тухай" А/1054 дүгээр захирамж – Хүчинтэй |
| | | Давхардал | Байхгүй. Энэ захирамжаар ERP систем ашиглах дотоод харилцааг зохицуулж өгсөн. |
| | | Хийдэл | Интернет цахилгаан тасрах үед албан хэрэг хөтлөлтийг тасралтгүй явуулах гарц гаргалгааг тусгаагүй, систем ажиллахгүй үед байгууллагын дотоод үйл ажиллагаа гацах эрсдэлтэй |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна. |
| Дүгнэлт:<br>Дүүргийн Засаг даргын А/364 дүгээр захирамж нь эрх зүйн үндэслэлийн хувьд хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцсэн байна.<br>Журамд системийн ашиглалт, хяналтын чиг үүргийг албан тушаалтан бүрээр нарийвчлан зааж өгсөн нь байгууллагын дотоод хяналтыг сайжруулахад чухал ач холбогдолтой байна. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА [signature] С.ТУУЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН [signature] О.ЯНЖИНЛХАМ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 10 өдөр

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2023 оны 06 дүгээр сарын 22, А/433<br>Журам батлах тухай<br>(Гэрлэх ёслолын өргөөний үйлчилгээний журам) | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг -(*Хүчинтэй)*<br>-Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 –(*Хүчинтэй)*<br>-Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2020 оны 03/01 тогтоол<br>*(Хүчинтэй)*<br>-Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 13/02 тогтоол<br>*(Хүчинтэй)* |
| | | Давхардал | Давхардалгүй |
| | | Хийдэл | Захирамжийн 2-р заалтад "Жаргалант тосгоны Соёлын ордон"-д журмын хэрэгжилтийг хангаж, дүрмээ өөрчлөхийг даалгасан байна. Хуулиараа соёлын байгууллага нь өөрийн үндсэн чиг үүрэгт (соёл, урлаг) нийцсэн үйлчилгээг үзүүлэх ёстой. Соёлын ордны дүрэмд "Гэрлэх ёслолын үйлчилгээ" гэсэн чиг үүрэг тусгагдаагүй бол энэ нь чиг үүргийн бус үйл ажиллагаа болох эрсдэлтэй. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Гэрлэх ёслолын өргөөний иргэдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны чиг үүрэг |
| Дүгнэлт:Албан ёсны "үйлчилгээний журам" гэсэн нэг баримт бичиг олон нийтэд нээлттэй байдаггүй. иргэдэд ээлтэй, гэр бүлд чиглэсэн олон талт үйл ажиллагаа явуулдаг ч мэдээллийн ил тод байдал сайжруулах шаардлагатай. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА [signature] С.ТУУЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН [signature] Б.МӨНХЗУЛ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 дугаар сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2024 оны 05 дугаар сарын 22<br>А/320<br>Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | МУЗЗНДНТУТХ-ийн 66 дугаар зүйлийн 66,1 дэх хэсэг - Хүчинтэй<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5,5, 9 дүгээр зүйлийн 9,1, 9,2, 18 дугаар зүйлийн 18,1, 18,2 дох хэсэг – Хүчинтэй |
| | | Давхардал | Комиссын бүрэлдэхүүнд орсон албан тушаалтнууд нь Архивын тасгийн үндсэн мэргэжилтнүүд байгаа нь тэдний ажлын байрны тодорхойлолтод заасан "баримт нягтлан шалгах" чиг үүрэгтэй давхцаж байна. Энэ нь зайлшгүй байх давхардал юм. |
| | | Хийдэл | Дүрмийн 5.2, 5.4-т комиссын гишүүдэд урамшуулал олгохоор заасан боловч энэхүү урамшууллыг ямар төсвөөс гаргах нь тодорхойгүй байна.<br>Хөмрөг үүсгэгч байгууллагууд баримтаа хэрхэн бэлтгэж, комисст ямар оувгаар хүсэлт гаргах процесс дүрмийн "Үйл ажиллагаа" хэсэгт нарийвчлан тусгагдаагүй байна.<br>Баримтыг нягтлан шалгах хүсэлтийг хүлээн авснаас хойш комисс хэд хоногийн дотор хуралдаж, эцсийн шийдвэр гаргах хугацааг зааж өгөөгүй байна. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн чиг үүргийг зохицуулна. |
| Дүгнэлт:<br>А/320 дугаар захирамж нь эрх зүйн үндэслэл сайтай, Архивын салбарын шинэчилсэн хууль тогтоомжид бүрэн нийцсэн байна. Гол анхаарах зүйл нь урамшууллын санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгох, ажлын хугацааг нарийвчлан тусгах шаардлагатай байна. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА [signature] С.ТУУЛМАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН [signature] О.ЯНЖИНЛХАМ

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2024 оны 10 дугээр сарын 30, А/613<br><br>Хот нийтийн аж ахуй гүйцэтгэлд хяналт тавьж санхүүжүүлэх,<br><br>тайлагнах журам | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -Монгол улсын засаг захиргаа,нутаг дэвсгэрийн нэгж,түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг -Хүчинтэй.<br>-Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь -Хүчинтэй. |
| | | Давхардал | Байхгүй (Хот нийтийн аж ахуйн гүйцэтгэлийг тооцох, хянах, санхүүжүүлэх харилцааг тухайлан зохицуулсан) |
| | | Хийдэл | Байхгүй (Хорооны Засаг даргаас эхлээд Санхүүгийн тасаг хүртэлх оролцогч талуудын чиг үүргийг заасан). |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх хот, нийтийн аж ахуйн чиглэлийн гэрээт ажлуудын гүйцэтгэлийг тооцох, хянах, санхүүжилт олгох, тайлагнах үйл ажиллагааг зохицуулна. |
| Дүгнэлт:<br>-Журам 2024.10.30-ны өдөр батлагдсан, 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж заасан учир зүйн хувьд алдаатай.<br>-Журмын 1.1 дүгээр заалт 1.2 дугаар заалтуудыг утга агуулын хувьд ижил тул нэгтгэх. Нийтлэг үндэслэл дээр 1.1 , 1.2 , давхардсан байна.<br>1.3. "Монгол Улсын" гэх үгийг орхиж бичсэн.<br>2.1 Хороон гэж бичсэн.<br>2.2.5. (48 цагын) буруу бичсэн.<br>2.4.5 дээр хороод гэж эзэн биегүй үүрэгжүүлсэн.<br>Хот нийтийн аж ахуйн чиглэлийн гэрээт ажлын гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналын тогтолцоог боловсронгуй болгосноор үйл ажиллагааны үр ашиг дээшилж, төсвийн зарцуулалт ил тод, нээлттэй хариуцлагатай болно. Ингэснээр гэрээний хэрэгжилт сайжирч, хяналтын үр нөлөө нэмэгдэн, иргэдэд хүрэх үйлчилгээний чанар, хүртээмж бодитоор дээшлэх ач холбогдолтой юм. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ш.ОУЮН-ЭРДЭНЭ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02сарын 10

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2025 оны 01 дүгээр сарын 13, А/18<br><br>Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан, хороодын засаг дарга нарын нэгдсэн шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журам | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг -Хүчинтэй байна. Нийслэлийн Засаг даргын 2017-оны А/334 дүгээр захирамж |
| | | Давхардал | Байхгүй |
| | | Хийдэл | 6.6 дугаар заалтад чөлөө авахдаа "нотлох баримтаа үзүүлэн" гэсэн боловч яг ямар баримт (эмнэлгийн магадлагаа, томилолтын тушаал гэх мэт) байхыг нарийвчлаагүй. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан, хороодын Засаг дарга нарын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангуулах, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, нийслэл дүүргийн удирдлагаас цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хангуулах чиглэлүүдээр мэдээлэл солилцох нэгдсэн шуурхай зөвлөгөөн зохион байгуулах харилцааг зохицуулахад журмын зорилго оршино. |
| Дүгнэлт:<br>Журмын зорилго нь дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтан, хорооны Засаг дарга нарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулахад чиглэгдсэн байна. Тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэх, нийслэл дүүргийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, мэдээлэл солилцоог нэгдсэн зохион байгуулалтад оруулах замаар удирдлагын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх ач холбогдолтой. | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН АЖИЛТАН Ш.ОЮУН-ЭРДЭНЭ

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 сарын 11 өдөр

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2025 оны 01 дүгээр сарын 24, А/36<br>“Журам батлах тухай”<br>Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах дулаан автобусны буудлуудын ашиглалтын журам | Хэрэгжиж буй эсэх | тийм |
| | | Үндэслэл (үндэслэл болгон авсан заалтууд хүчин төгөлдөр эсэх) | -“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг-хүчинтэй<br>-Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.4 орон нутгийн өмчийн эд хөрөнгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, эд хөрөнгийн тооллого явуулах ажлыг зохион байгуулах;, 78.7 нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах гэх заалт-хүчинтэй<br>-Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг үндэслэсэн-хүчинтэй.<br>**Журамд орсон эрх зүйн актууд:**<br>-Зөрчлийн тухай хууль<br>-Захиргааны ерөнхий хууль 37 дугаар зүйлийн 37.1 |
| | | Давхардал | Байхгүй. |
| | | Хийдэл | -Журмын 3.4-т ашиглагч байгууллага, хороо болон цэвэрлэгээний байгууллага гэсэн гуравласан гэрээ байгуулахаар заасан аль нэг тал үүргээ биелүүлэхгүй бол хэн эцсийн хариуцлага хүлээх тухай тодорхой заагаагүй.<br>-Өвлийн улирлаас бусад улиралд хэрхэн ашиглах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй.<br>-Журмын 6.2-т зөрчлийн тухай хуулиар шийдвэрлүүлнэ гэж заасан үндэслэл хэсэгт Зөрчлийн тухай хуулийг тусгаагүй. |
| | | Зохицуулж буй чиг үүрэг | Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах дулаан автобусны буудлуудын ашиглалт, хамгаалалт, үйл ажиллагаанд дагаж мөрдөх хэм хэмжээг тодорхой болгохоор заасан. |
| **Дүгнэлт:** Захирамж нь 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр гарсан болович , журмыг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байна. Энэ нь захирамж гарахаас өмнөх хугацаанд дагаж мөрдөхөөр заасан нь учир зүйн алдаатай.<br>4.1.3-т өвлийн улирлын хугацааг 11 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 31-нийг дуустал гэж заасан байна. 04 дүгээр сар нь 30 хоногтой тул мөн алдаа гаргасан. Захирамжийн үндэслэл хэсэгт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 4, 7 дахь заалт гэж захирамжийн үндэслэлд хуулийн заалтыг буруу оруулсан.<br>Захиргааны ерөнхий хуулийн зүйл заалтыг үндэслэл хэсэгт оруулаагүй. Дахин шинэчлэн гаргах шаардлагатай | | | |

ТАНИЛЦСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ш.ОУЮН-ЭРДЭНЭ

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ХЭРЭГЖИЖ БУЙ ДҮРЭМ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2026 оны 02 дугаар сарын 11

| Д/д | Баримт бичгийн нэр | Шалгуур үзүүлэлт | Одоогийн байдал |
|---|---|---|---|
| Дүүргийн Засаг даргын захирамж | | | |
| 1. | 2025 оны 03 дугаар сарын 26 А/162<br><br>Ажлын хэсэг байгуулах тухай<br><br>Сонгинохайрхан дүүргийн удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтын журам | Хэрэгжиж буй эсэх | Тийм |
